

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар хийх үед төсвийн тооцоололтой холбоотойгоор шаардлагатай бол холбогдох хууль, тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн байнгын хороо Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувиар бүрдүүлдэг байсныг 10 хувь болгон өөрчлөхөөр тусгасан болно.


Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 75.0 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ч.ХҮРЭЛБААТАР